БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 24 өдөр Дугаар 104 Номгон

Аж ахуй нэгж байгууллагуудыг
камержуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.3 дахь заалт, Аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрөл олгох тухай хуулийн 11.1.6-т заасныг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн амар тайван амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх, өмч хөрөнгийг гэмт хэрэг халдлагаас хамгаалах, гэмт хэрэг зөрчлийг цаг алдалгүй шуурхай илрүүлэх, таслан зогсоох зорилгоор Баянхонгор сумд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагууд, зах, худалдааны төвүүд, томоохон аж ахуй нэгж, байгууллага, шатахуун түгээх станц, сургуулиудын нийтийн бие засах газар, банк бус санхүүгийн байгууллагуудыг камержуулах, хуулийн хүрээнд тухайн аж ахуй нэгж, байгууллагуудын гадна орчинд нэмэлтээр суурилагдах хяналтын камерыг Цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээнд үнэ төлбөргүй холбож, ажиллахыг аж ахуй нэгж, байгууллагуудын дарга, эрхлэгч, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

2. Монгол улсын стандарт MNS 6423:2019 үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон хяналтын камерын чанар, стандарт, шаардлагын талаар албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд чиглэл өгч ажиллахыг Цагдаагийн газарт, аж ахуйн нэгж, байгууллагууд шөнийн цаг буюу 22.00 цагаас 06 цаг хүртэл байгууллагын гадна талын гэрэлтүүлгийг асааж байх, ямар төрлийн гэрэлтүүлэг суурилуулах талаар чиглэл өгч ажиллахыг “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

1190177

4. Энэ тогтоолыг баталсантай холбоотойгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 148 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



ДАРГА Ц.ОТГОНБАЯР